



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар Б/15.

Хэрлэн сум

Б.Мөнх-Оргилыг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн 3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эдийн засаг, хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалд ажлын зайлшгүй шаардлагаар Баяржаргалын Мөнх-Оргилыг 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласугай.

2.Б.Мөнх-Оргилыг цалинг Т3-5-1 шатлалтай адилтган тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Мөнх-Оргилд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

· 231030154